

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн төгсөгчдийн холбоо болон 2014 оны төгсөгч нарын хамтран зохион байгуулсан үе үеийн төгсөгчдийн волейболын аварга шалгаруулах тэмцээн амжилттай болж өндөрлөлөө



Оёдлын мэргэжлийн ур чадварын "Уран учиг" уралдаан 2024 оны 04 дугаар сарын 04-ний өдөр амжилттай зохион байгуулагдлаа



Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж нь 2023–2024 оны хичээлийн жилд олон улсын IT хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байгаа билээ

- Энэхүү хөтөлбөрийн хүрээнд олон улсын стандартад нийцэхүйц өндөр хүчин чадал бүхий мэдээллийн технологийн лабораторийг шинээр байгуулан 2024 оны 04 сарын 10-ны өдөр албан ёсны нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа



Чингис хаан музей Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн хамтын ажиллагааны боловсролын хөтөлбөрийн хүрээнд МБС – ын 1-р ангийн 7 мэргэжлийн нийт 170 суралцагчийг музейн хөтөлбөрт үйл ажиллагаанд оролцууллаа



СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдаж буй **МОНГОЛЫН БАГШ НАРЫН 8 ДУГААР ИХ ХУРЛЫН** салбар хэлэлцүүлгийн панелистаар сонгогдож хуралд Үсчин мэргэжлийн багш Д.Одгэрэл төлөөлөн оролцлоо.



Ховд ПТК Үйлдвэр урлал ПТК багууд тоглож, 2:0 харьцаагаар Үйлдвэр урлал ПТК-н баг тамирчид хожлоо.



Дорнод аймаг дахь түүхт 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын **"УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН-2024"**- ийн Волейболын төрөлд Үйлдвэрлэл урлалын Политехник коллежийн Ч.Ариунтуяа ахлагчтай баг тамирчид Тэргүүн байр эзэлж Ч.Ариунтуяа багш Шилдэг Тэгш тоглогч боллоо. Мөн шатрын төрөлд Н.Тэрбиш, Н.Урантогос нар тусгай байранд шалгарлаа



Техникийн болон мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын багш суралцагчдын дунд жил бүр зохион байгуулагддаг улсын **"ХИМИЙН-ХИХ"** олимпиадад 14 сургуулийн 16 багш, 41 суралцагчид оролцож ҮҮПК-ийн химийн багш Да.Солонго нь тусгай байр эзэллээ



СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024 оны 04-р сарын 16-ны өдөр Сүхбаатар дүүргийн цагдаагийн 2-р хэлтсийн хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн ахлах дэслэгч Б.Занабазар "Үе тэнгийн дээрэлхэлт" сэдвээр, өмгөөллийн Карат консалтинг ХХК-ний өмгөөлөгч Ө.Одончимэг "Архины хор уршиг" сэдвээр тус тус яриа таниулга хийж Э.Энхнаран багштай Өгөгдлийн сангийн оператор 1а, Х.Энхчимэг багштай Оёмол бүтээгдэхүүний оёдолчин 1а, Ж.Лосолмаа багштай Цахим тоног төхөөрөмжийн үйлчилгээний ажилтан 1а, Д.Болор-Эрдэнэ багштай Зочид буудал, жуулчны баазын үйлчилгээний ажилтан 1а, Ц.Номин-Эрдэнэ багштай Гагнуурчин 1а, Л.Болормаа багштай Үсчин 1а, Э.Батбилэг багштай Зураач чимэглэгч 1а нийт 7 ангийн суралцагч хамрагдаж мэдлэг ойлголтоо нэмэгдүүллээ



БШУЯ-ны Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын дарга А.Халиунаа бусад шинжээчдийн хамтаар 2024.04.18-ны өдөр тус сургуулийн сургалтын орчин, хөтөлбөрийн хэрэгжилт шинэ болон шинэчилсэн дүрэм журмын биелэлттэй танилцаж, зөвлөгөө өглөө



Хангай МСҮТ-өөс 12 дах удаагаа зохион байгуулагдсан "ОФФИСЫН БОЛОН БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН" мэргэжлийн ур чадварын улсын уралдаанд НБДАХА 2а ангийн суралцагч Э.ЭрдэнэчимэгТЭРГҮҮН байр эзэлж нийт дүнгээрээ багаараа 3-р байр эзэллээ



СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

БМИУЗ-өөс Дотоод чанарын баталгаажилтын ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг тус сургууль дээр 2 өдөр амжилттай зохион байгууллаа



Үсчин, Гоо засалч мэргэжлээр суралцаж буй оюутан суралцагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор УРАН ЧАВХДАС-2024 уралдааныг зохион байгууллаа



Энэхүү уралдаанд Гоо заслын мэргэжлийн түвшний 57, IV түвшний 27, V түвшний 10 суралцагчид, 20 төрлөөр оролцсон бол Үсчин мэргэжлээр суралцаж буй 5 ангийн 108 оюутан / давхардсан тоогоор / 13 төрлөөр оролцож оюутан суралцагчид маань оюун ухаан хурд хүчээ уралдуулан амжилттай оролцлоо

БОЛОВСРОЛЫН БАГЦ ХУУЛЬ, САЛБАРЫН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААРХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

БШУЯ, БШУҮЭ-ийн хороо, ҮУПК-ийн захиргаа Үйлдвэрчний эвлэлийн хороо хамтран нийт багш ажилчдад хуулийн шинэ орчинд ажиллаж амьдрах, бүх нийтийн ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ сургалтын чанарыг ахиулах, нийгмийн баталгаагаа ахиулах зэрэг олон шинэлэг мэдээллийг олгосон сургалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа



Сургалтын орчин нөхцөлийг сайжруулах, эрсдэлт хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эерэг соёлыг түгээх болон багш, ажилтан суралцагчдын ХАБЭА-н мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор жил бүрийн 4-р сард "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян"-ыг зохион байгууллаа



СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тогооч, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний техник технологич мэргэжлээр суралцагчдын "Ур чадвар-2024" тэмцээн амжилттай зохион байгуулагдлаа



Тус тэмцээнд тогооч 1, 2 анги хоол үйлдвэрлэлийн техник технологич мэргэжлийн нийт суралцагчид хамрагдаж II-V түвшингийн хүндрэлээр ялгаатай даалгавар гүйцэтгэлээ



GRAND TOUR-2024 Аялал жуулчлалын улсын XXII олимпиадын **CESIM SERVICE** бизнес загварчлалын цахим тэмцээнд Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн Зочид буудал зоогийн газрын үйлчилгээний ажилтан Зочид буудал жуулчны баазын үйлчилгээний ажилтан мэргэжлийн ангийн оюутнууд амжилттай оролцлоо

Тус тэмцээнд 18 их дээд сургууль оролцож амжилттай болж өндөрлөлөө

Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежоос 21 мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагын англи хэлний багш оюутан суралцагчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Англи хэлний улсын-XXI" олимпиад амжилттай болж өндөрлөлөө



Сүхбаатар дүүргийн ЕБС-ийн захиргааны ажилтнуудын дунд зохиогдсон Спортын 5 төрөл тэмцээнд баг хамт олноороо амжилттай оролцож 3х3 сагсан бөмбөгийн төрөлд ГУТГААР" байр эзэллээ



СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Оросын Холбооны Улсад 2024 оны 04 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд өөрийгөө хамгаалах үйл ажиллагааг дэлхийд түгээх болон гадаад тамирчидтай найрсаг харилцааг бэхжүүлэх зорилгоор Дэлхийн аварга шалгаруулах "Гардан тулаан"-ы тэмцээн зохион байгуулагдлаа

Тус тэмцээний өсвөр насны ангилалд манай сургуулийн Вэб мультимедиа 1а ангийн суралцагч Монголын гардан тулааны холбооны тамирчин Мягмарсүрэн овогтой Мөнхдөл Дэлхийн аваргын "Хүрэл" медаль хүртлээ



АЖИЛЧДЫН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА, ХӨДӨЛМӨРЛӨХ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР ОЙЛГОЛТ МЭДЭЭЛЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



Соёлтой иргэн Соёлтой дүүрэг нөлөөллийн аянд Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл урлалын политехник коллеж нэгдлээ



Соёлын яам, Монголын ерөнхий боловсролын Дунд Сургуулиудын холбооны дэргэдэх "HUGO and COLOR" клубын нэрэмжит хүүхдийн гар зургийн улсын XVОлимпиадад Бэлэг дурсгал 2а ангийн 3 суралцагч "Чимэглэх урлаг" төрөлд оролцож Т.Энхмандуул 3-р байр, М.Машидбат тусгай байр, О.Адъяасүрэн амжилттай оролцлоо

